

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛЭЭР ХҮНИЙ АМЬ НАС, ЭРҮҮЛ МЭНД, ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИНД АЮУЛ, ХОХИРОЛ УЧРУУЛЖ БОЛЗОШГҮЙ АЧАА ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь автотээврийн хэрэгслээр хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул, хохирол учруулж болзошгүй ачаа (цаашид "аюултай ачаа" гэх) тээвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах, хяналт тавихад оршино.

1.2. Аюултай ачаа тээвэрлэх аж ахуйн нэгж байгууллага нь тухайн төрлийн аюултай ачааг тээвэрлэх тээвэрлэлтийн маршрут, цагийн хуваарийг баталгаажуулан, автотээврийн хэрэгсэл болон тээвэрлэх ачаа, хүний нөөцийн талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрөл олгох эрх олгогдсон байгууллагад урьдчилан гарган өгч, тээвэрлэлтийн зөвшөөрлийг авсан байна.

1.3. Улс хоорондын аюултай ачаа тээвэрлэлтийг Олон улсын автотээврийн харилцааны тухай хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

1.4. Аюултай ачааны тээвэрлэлтийг энэхүү журам болон бусад салбарын эрх зүйн актуудаар тусгайлан эрх олгогдож баталсан аюултай ачаа тээвэрлэхтэй холбоотой журам, заавар, аргачлалын дагуу гүйцэтгэнэ.

1.5. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Цагдаагийн байгууллагын хамтран баталсан "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тээвэрлэлтийн аюулгүй ажиллагааны журам"-ын дагуу тээвэрлэнэ.

1.6. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг энэхүү журам болон эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах зааврын дагуу тээвэрлэнэ.

1.7. Химийн хорт болон аюултай бодисыг энэхүү журам болон "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-д заасан нэмэлт шаардлагын дагуу тээвэрлэнэ.

1.8. Аюултай хог хаягдлыг Монгол Улсын Засгийн газраас баталсан "Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам"-ын дагуу тээвэрлэнэ.

Хоёр. Аюултай ачааны тээвэрлэлт

2.1. "Аюултай ачаа" - тээвэрлэлтийн үед хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөл тарих, эд хөрөнгийн хохирол учруулж болзошгүй элдэв бодис, түүгээр хийсэн эд зүйл, үйлдвэрийн хаягдал, аж ахуйн зориулалт бүхий бусад зүйл болон тэдгээрийн ариутгаагүй сав, баглаа, боодлыг; гэж Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрэмд заасныг ойлгоно.

2.2. Аюултай ачааг холбогдох стандартуудад тусгагдсан техникийн шаардлагыг хангасан тухай автотээврийн хяналтын улсын байцаагчийн дүгнэлттэй, аюултай ачааны таних тэмдэг

болон аюулын шинж чанарын талаар санамж байрлуулсан зориулалтын тээврийн хэрэгслээр, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн тээвэрлэнэ.

2.2. Аюултай ачааг хүн, мал, амьтан болон өөр бараа бүтээгдэхүүнтэй хамт болон шуудан тээвэр, нийтийн тээврийн хэрэгсэл, суудлын автомашин, ердийн хөсгөөр тээвэрлэхийг хориглоно.

2.4. Аюултай ачааны хайрцаг, сав нь гэмтэлтэй, автотээврийн хэрэгсэл нь бүрэн бус, баримт бичгийн бүрдэл хангаагүй тохиолдолд тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

2.5.Тээвэрлэлтийн үед ачаа унах, сав баглаа боодол гэмтэх, холилдохоос сэргийлэн, ачааг зөв байрлуулж, хөдөлгөөнгүй сайтар бэхэлсэн байна. Автотээврийн хэрэгслийг бүрэн унтраасны дараа ачааг ачиж, буулгахыг зөвшөөрнө.

2.6.Тээвэрлэлтийн явцад аливаа саатал гарч зайлшгүй зогсох шаардлага гарвал авто замыг чөлөөлөх арга хэмжээг авах бөгөөд боломжгүй тохиолдолд зорчих хэсгийг чөлөөлж, автотээврийн хэрэгслээс хоёр тийш 100м зайд "Орохыг хориглоно" тэмдгийг байрлуулахаас гадна замын хөдөлгөөний дүрэмд заасны дагуу зайлшгүй зогсолтын үед авах арга хэмжээг хэрэгжүүлэн бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулж, аюул ослоос сэргийлнэ.

2.7. Их хэмжээтэй шингэн түлш /шатахуун/, шахсан хийг зориулалтын автоцистернээр тээвэрлэнэ. Автоцистерн ба чиргүүлийн торхны баруун, зүүн гадна талд "Галын аюултай" гэсэн үгийг хурц ялгарах тод өнгөөр заавал бичих бөгөөд мөн аюулын шинж чанарыг тодорхойлсон таних тэмдгийг байрлуулсан байна.

2.8. Аюултай ачаа ачсан автотээврийн хэрэгслийг зориулалтын түлш тээвэрлэгч автоцистерн ашиглан цэнэглэнэ.

2.9. Тээвэрлэгч нь тээвэрлэлтийн талаарх мэдээллийг тухайн аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, цагдаагийн байгууллагын бүртгэл хяналтын төв, тээвэрлэлт зохион байгуулах болон хяналт тавих эрх бүхий байгууллагад хүргүүлж ажиллана. Энэхүү мэдээлэл нь цахим хэлбэртэй байж болно.

2.10. Бага хэмжээний шингэн түлшийг төмөр торхонд, шахсан хийг баллонд тээвэрлэнэ. Өргөн хэрэглээний шахсан хий /шингэрүүлсэн шатдаг хий/-г бага хэмжээ /1.5 тонноос доош/-гээр хотын дотор түгээнэ.

2.10.1.баллон баталгаажуулах эрх бүхий байгууллагаас техникийн магадлал хийж баталгаажуулсан хоосон болон шахсан хийтэй баллоныг тээвэрлэлтэд хүлээн авна. Баллон нь цэнхэр өнгөөр будагдсан, дээр нь хар өнгийн тосон будгаар ачааны нэрийг нь бичсэн байх ба түүний мөрөн дээр үйлдвэрийн марк, үйлдвэрлэсэн он, баллоны дугаар, даралтын хэмжээ, дахин шалгах хугацааг заасан байна;

2.10.2.баллонтой шахсан хийг тээвэрлэхэд хоногтой, хоног нь дотроо резинэн зөөлөвчтэй хөндөл дэр мод 2-3-ыг тэвшний уртааш хөдөлгөөнгүй байрлуулж тэдгээрийн хоногонд баллоныг, тагийг нь нэг тийш харуулан ачина. Үе хооронд резинэн зөөлөвч бүхий хоёр талдаа хоногтой модон хөндлөөр жийрэглэж, дээд үеийг талдаа хоногтой хөндлөвчөөр таглана. Баллонуудыг холхих хөдөлгөөнгүй байрлуулсан байвал зохино.

2.10.3. баллоныг босоо байрлалд эргүүлгэн хаалтуудыг нэг зүг рүү харуулж байрлуулан хооронд нь жийрэг тавьж ачиж болно. Баллонд жийргийн зориулалтаар баллон тавих ховил гарган хийсэн хөндлөн мод, мөн 25 мм-ээс багагүй зузаантай олсон буюу резинэн цагираг /нэг баллонд хоёр цагираг/ хэрэглэж болох бөгөөд эсвэл баллонууд өөр хоорондоо мөргөлдөхөөс сэргийлсэн бусад жийрэг хэрэглэж болно.

2.10.4. баллонтой хийг хэт халахаас сэргийлэх арга хэмжээг авах ба тостой алчуур, торхтой шатахуун, тослох материалтай хамт ачихыг хориглоно.

2.10.5.хоосон баллонд үлдэгдэл даралт байх тул түүний тээвэрлэлт нь цэнэглэсэн баллоныг тээх бүх шаардлагыг хангасан байна.

2.11. Автомашинд шингэрүүлсэн хийн түлшний зориулалтаар ашиглаж буй баллон нь хаалт, хамгаалах хавхалгаас гадна дүүргэлтийн дээд түвшинг заах хэмжүүртэй байх ёстой. Ийм зориулалттай баллонд дүүргэлтийн тусгай хавхлаг, ууршилтын төлөвд байгаа хий авах хаалт, баллон дахь шингэрүүлсэн хийн түвшин хэмжигч, хий гаргах хаалт зэргийг тавьж болно.

2.12.Хүчил, шүлт зэрэг идэмхий шингэнийг үйлдвэрлэгчээс савласан зориулалтын тусгай шилэн саванд тээвэрлэнэ. Шилэн сав нь гадуураа модон хайрцаг, гөрмөл шээжгий, давхар савтай байна. Автотээврийн хэрэгслийн тэвшинд шилэн савны хоолой /таг/-г дээш харуулж босоогоор хөдөлгөөнгүй байхаар бэхэлж ачина.

2.13. Аюулын зэрэг өндөр химийн хорт болон аюултай бодис бүхий ачааг зөвхөн өдрийн цагаар ачиж буулгах ба түүний ачааны тэмдгэнд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна.

2.14. Аюултай ачаа тээвэрлэх жолооч нь /цуваагаар тээвэрлэх үед цувааны ахлагч нь/ замын хөдөлгөөний эрчим, автотээврийн хэрэгслийн онцлог байдал, тээж яваа ачаа, замын болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний дагуу үзэгдэлтийг харгалзан хоорондын зайг барьж, хурдыг тухайн тээврийн хэрэгслийн зөвшөөрөгдөх дээд хурд, замын хөдөлгөөний дүрмээр тогтоосон хязгаараас хэтрүүлэхгүйгээр сонгон, өдрийн цагт ойрын гэрлээ асааж явна.

2.15. Аюултай ачааг 3-аас илүүгүй тооны автотээврийн хэрэгслийг оролцуулан цуваагаар тээвэрлэх ба дараах шаардлагуудыг хангуулсан байна. Үүнд:

2.15.1. тээвэрлэлтийн аюулгүй байдлыг хариуцахаар томилогдсон ажилтан /цувааны ахлагч/ цувааг зохион байгуулж, зөвшөөрөгдсөн маршрутын дагуу замын хөдөлгөөний дүрэм, аюултай ачааны стандарт, аюулгүй ажиллагааны зааврыг баримтлан аюултай ачааг тээвэрлэх үйл ажиллагааг удирдана.

2.15.2. цувааны ахлагч цувааны эхний автомашинд явах бөгөөд цувааны эхэнд хамгаалалтын автомашин, төгсгөлд нөөц автомашин явна.

2.15.3. цувааны эхний болон сүүлчийн автомашин "цуваа" гэсэн тод бичлэгтэй байх ба цуваанд эзлэх дугаарыг автомашин бүрийн урд болон ард талд харагдахуйцаар жигд байрлуулна.

2.16. Аюултай ачаа тээвэрлэх бусад шаардлагыг аюултай ачаа тээвэрлэх техникийн нөхцөл, стандартад тусгана.

2.17. Аюултай ачаа тээвэрлэсэн автотээврийн хэрэгслийг сайтар цэвэрлэж, хоргүйжүүлнэ

2.18. "Автотээврийн хэрэгсэл нь байршил тогтоох төхөөрөмж (GPS), эсхүл тахографоор тоноглогдсон байх бөгөөд тэдгээр нь хяналт тавих эрх бүхий байгууллагын сүлжээнд холбогдсон, бүрэн ажиллагаатай, мэдээлэл дамжуулах боломжтой байна

Гурав. Аюултай ачаа тээвэрлэгч, тээвэрлүүлэгчийн хүлээх үүрэг

3.1.Тээвэрлүүлэгчээс тээвэрлэлтэд бэлтгэсэн аюултай ачаа нь зориулалтын сав, баглаа боодолтой, стандартын шаардлага хангасан англи эсвэл монгол хэл дээр үйлдэгдсэн хаяг, шошготой байна.

3.2.Тээвэрлүүлэгч нь үйлдвэрлэгчээс гаргасан хор аюулын лавлах мэдээллийг үндэслэн аюултай ачаа нэг бүрээр боловсруулсан аюулгүй ажиллагааны зааварчилгааг байгаль орчны болон гамшгаас урьдчилан сэргийлэх хяналтын улсын байцаагчаар хянуулж, баталгаажуулсан байна.

3.3. Аюултай ачаа тээвэрлэх автотээврийн хэрэгсэл нь техникийн хяналтын үзлэгт хагас жил тутам (жилд 2 удаа)-д хамрагдаж, тэнцсэн байна.

3.4.Тээвэрлэгч нь аюултай ачаа тээвэрлэх автоцистерн, чиргүүлийн торхыг, тээвэрлүүлэгч нь шахсан хийн баллоныг тухайн аймаг, нийслэлийн стандартчилал, хэмжил зүйн газар, хэлтсээр баталгаажуулсан байна.

3.5.Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь тухайн аймаг, нийслэлийн онцгой байдлын асуудал эрхэлсэн газар, хэлтсээр аюултай ачааг ачиж, буулгах, тээвэрлэх үйл ажиллагаатай холбоотойгоор гарч болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулж батлуулсан

3.6. Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь аюултай ачааны автотээврийн хэрэгсэл, автотээврийн хэрэгслийг хадгалах байр, талбай, зогсоолын аюулгүй ажиллагаанд галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан байна.

3.7.Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь аюултай ачааг ачиж, буулгах ажилтан, тээвэрлэх автотээврийн хэрэгслийн жолооч болон түүнийг дагалдан явах ажилтанд аюулгүй ажиллагааны зааварчилгаа, аюултай ачаа тус бүрийн хор аюулын лавлах мэдээлэл, болзошгүй ослын үед ажиллах төлөвлөгөө, тээвэрлэх маршрут зэргийг танилцуулж гарын үсэг зуруулсан байна..

3.8. Тээвэрлэлтийн гэрээ /ачаа дагалдах бичиг/, замын хуудсыг жолооч заавал биедээ авч явна. Ачааны дагалдах бичиг нь холбогдох мэдээллийг агуулсан QR код байж болно.

3.9. Тээвэрлэгч нь аюултай ачааны тээвэрлэлтийг зөвхөн аюултай ачаа тээвэрлэх чиглэлээр сургалтад хамрагдаж мэргэшсэн жолоочоор гүйцэтгүүлэх үүрэг хүлээнэ

3.10. Аюултай ачаа тээвэрлэх автотээврийн хэрэгслийг хот, суурин газарт зориулалтын бус гарааш, зогсоолд, орон сууцны хорооллын дунд болон хүн ам олноор төвлөрч суурьшсан газарт тавихыг хориглоно.

3.11. Аюултай ачаа тээвэрлэх жолооч, тээвэрлэлт хариуцсан ажилтан нь олон улсад хүлээн зөвшөөрөгдөж эрх олгогдсон байгууллагын тусгайлсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.

3.12. олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий байгууллага дор дурдсан агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөрийг баталж, зохион байгуулна. Үүнд:

3.12.1. улс хоорондын болон дотоодын аюултай ачаа тээвэрлэлтийн нөхцөл байдал, гэрээ, хэлэлцээрүүд

3.12.2. аюултай ачааны ангилал

3.12.3. аюултай ачааны савалгаа ба шошго

3.12.4. аюултай ачааны тээвэрлэлтийн баримт бичгүүд

3.12.5. тээврийн хэрэгсэлд тавих техникийн шаардлагатай холбоотой стандартууд

3.12.6. тээвэрлэлтийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдал

3.12.7. ачааг аюулгүй ачих, бэхлэх, буулгах аргууд

3.12.8. осол, саатлын үед ажиллах зааварчилгааг дагаж мөрдөх талаар

3.12.9. бусад

3.13. сургалт нь үндсэн, цистернийн болон тухайн ангиллын аюултай ачааны сургалтаас бүрдэнэ.

3.14. сургалтад хамрагдсан жолооч, тээвэрлэлт хариуцсан ажилтнаас шалгалт авч энэхүү журмын нэг болон хоёрдугаар хавсралтад заасан загварын дагуу гэрчилгээг олгоно.

3.15. сургалтын байгууллага нь хууль эрх зүйн орчин шинэчлэгдсэн, тээвэрлэлтийн нөхцөлд шинээр шаардлага бий болсон тохиолдолд жолооч, тээвэрлэлт хариуцсан ажилтныг давтан сургалтад хамруулна.

3.16. сургалтын байгууллага нь сургалтад хамрагдсан жолооч, тээвэрлэлт хариуцсан ажилтнуудын талаар мэдээллийн сан хөтөлж, төрийн захиргааны төв байгууллагыг мэдээллээр хангах үүрэг хүлээнэ.

3.17.Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн явцад болзошгүй аюул учирсан тохиолдолд хэрэглэх, хор уршгийг арилгах зориулалтын багаж, хэрэгсэл /гал унтраагуур, хүрз, лоом, сүх, шуудайтай элс, хувин г.м/, хор саармагжуулах бодис, уусмал, арьс болон амьсгал хамгаалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан хүн нэг бүрийн хамгаалалтын хэрэгслэл зэргээр автотээврийн хэрэгсэл бүрийг хангасан байна.

3.18. Аюултай ачааг тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь тээвэрлэлтийн явцад дотоодын хяналт тавих, хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, гарсан хор уршгийг арилгах арга хэмжээг өөрийн зардлаар авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.19.Тээвэрлэгч, тээвэрлүүлэгч нь аюултай ачаа тээвэрлэлтэй холбогдсон мэдээллийн цахим сан үүсгэж, тухай бүр шинэчилж, холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангана.

Дөрөв. Аюултай ачаа тээвэрлэлтэнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага

4.1.Аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтэд нийслэл, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа автотээврийн байгууллагууд, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар, замын хөдөлгөөний аюулгүй байдалд цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтнууд хэрэгжүүлнэ.

4.2. Тээвэрлэлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд эрх бүхий байгууллагууд, эсхүл эрх олгогдсон байгууллага хяналт тавьж ажиллана. Хяналт нь цахим хэлбэртэй байж болно.

4.3.Автотээврийн хяналтын улсын байцаагч, замын хөдөлгөөний аюулгүй байдалд хяналт тавих цагдаагийн байгууллагын ажилтан нь аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдсон зөрчлийг илрүүлсэн тохиолдолд холбогдох байгууллагатай яаралтай холбоо тогтоож болзошгүй аюул, ослыг таслан зогсоох арга хэмжээ авна.

4.4.Иргэд, байгууллага нь аюултай ачаа тээвэрлэхтэй холбогдолтой хууль тогтоомж зөрчигдөж байгаа талаарх санал, хүсэлтээ холбогдох төрийн аль ч шатны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх эрхтэй.

4.5.Энэхүү журмыг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Автотээврийн хэрэгслээр хүний амь нас,
эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул,
хохирол учруулж болзошгүй ачаа
тээвэрлэх журам”-ын нэгдүгээр хавсралт

АЮУЛТАЙ АЧААНЫ ЖОЛООЧИЙН ГЭРЧИЛГЭЭ ADR DRIVER TRAINING CERTIFICATE

MN



1. MN00000000
2. СЭРЭЭТЭР
SEREETER
3. ЛХАМСҮРЭН
LKHAMSUREN
4. 14.11.1977
5. MONGOLIAN
6. Сэрээтэр
7. THE PROFESSIONAL EDUCATION
INSTITUTE OF ROAD, TRANSPORT
SPECIALISTS (PEIRTS)
8. 20/04/2029

ТЭЭВЭРЛЭХ ЭРХТЭЙ АНГИЛАЛ БА НҮБ-ЫН ДУГААР

VALID FOR CLASS(ES) OR UN Nos:

Цистерн

TANKS

9. 1
2
3
4.1 4.2 4.3
5.1 5.2
6.1 6.2
7
8
9

Цистернээс бусад

OTHER THAN TANKS

10. 1
2
3
4.1 4.2 4.3
5.1 5.2
6.1 6.2
7
8
9



“Автотээврийн хэрэгслээр хүний амь нас,
эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд аюул,
хохирол учруулж болзошгүй ачаа
тээвэрлэх журам”-ын хоёрдугаар хавсралт

АЮУЛТАЙ АЧААНЫ ЗААВАРЛАГЧИЙН

ГЭРЧИЛГЭЭ

ЛХАМСҮРЭН овогтой СЭРЭЭТЭР нь

2024 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 4 дүгээр сарын 15 ны өдрүүдийн хооронд
“Аюултай ачааны зааварлагч”-ийн сургалтад хамрагдаж төгссөн тул гэрчилгээ олгов.

ЗААВАРЛАХ ЭРХИЙН АНГИЛАЛ

Цистерн

1
2
3
4.1 4.2 4.3
5.1 5.2
6.1 6.2
7
8
9

Цистернээс бусад

1
2
3
4.1 4.2 4.3
5.1 5.2
6.1 6.2
7
8
9



Хүчинтэй хугацаа: 2029 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр